



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалт, Өмнөговь аймгийн Засаг даргын 2023 оны А/2288 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 68,704,900.00 (жаран найман сая долоон зуун дөрвөн мянга есөн зуу) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Отгонбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001606

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 26 дугаар сарын 13-ны өдрийн
292 дүгээр тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Зөөврийн компьютер	ш	5	3,080,000.00	15,400,000.00
2	Суурин компьютер	ш	3	2,970,000.00	8,910,000.00
3	Дэлгэц	ш	3	891,000.00	2,673,000.00
4	Принтер /Өнгөт/	ш	1	1,052,700.00	1,052,700.00
5	Принтер /Хар ласер/	ш	8	482,900.00	3,863,200.00
6	Скайнер /2 талдаа татдаг скайн/	ш	4	2,365,000.00	9,460,000.00
7	Принтер /Printer all in one/	ш	1	2,927,100.00	2,927,100.00
8	Digital camer	ш	1	3,023,900.00	3,023,900.00
9	Улсын бүртгэлийн киоск машин	ш	1	19,800,000.00	19,800,000.00
10	Принтер /31 pinger printer/	ш	1	935,000.00	935,000.00
11	Улсын бүртгэлийн дотоод сүлжээний төхөөрөмж /VPN/	ш	1	660,000.00	660,000.00
	Нийт дүн				68,704,900.00 (жаран найман сая долоон зуун дөрвөн мянга есөн зуун)